



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 4 сарын 20 өдөр

Дугаар 15

Сүхбаатар сум

Хушаат сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт
шалгалтын дүн

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

1.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 15 дугаартай "Санхүүгийн хяналтын ажлын удирдамж"-аар Хушаат сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүү төсвийн гүйцэтгэл болон Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг хянан шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх засаж залруулах зорилготойгоор хяналт шалгалт хийлээ.

1.2 Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Дотоод аудитор, СХШУБ Ц.Уртнасан 2024 оны 11 дугаар сарын 04-ний өдрөөс ажлын 15 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1.3 Шалгалтад Хушаат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал (цаашид ИТХ гэх)-ын 2024 оны 3 дугаар улирлын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааны баримт материал, тайлан тооцоог хамруулав.

1.4 Хушаат сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь улсын бүртгэлийн 8317178 регистртэй, төрийн сан дах үндсэн үйл ажиллагааны 100131754001 данстай.

Санхүү, татварын баримтад 1 дүгээр гарын үсгийг ИТХ-ын нарын бичгийн дарга Ж.Алтанцэцэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнхзул нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, мэдээ тайлан гаргаж ирсэн байна.

1.5 Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/01 дугаар тушаалаар ИТХ-ын ажлын албаны бүтэц орон тоог баталсан байна.

Сумын ИТХ нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Нутгийн удирдлага, хууль зүйн хяналтын бодлогын хороо, Хөгжлийн бодлогын хороо, Нийгмийн бодлогын хороо, ХАА, байгаль орчны бодлогын хороо зэрэг Хурлын

хороо 4-г байгуулан ажиллуулж Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

1.6 Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулдаг. Тайлант хугацаанд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан 3 удаа, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл 6 удаа, багийн иргэдийн Нийтийн Хурал тус бүр 1 удаа хуралдсан байна. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаан, багийн иргэдийн Нийтийн Хуралдаан, сургалт, бодлогын хороодын хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэгт ажлын албаны зүгээс анхаарч ажилласан байна.

1.7 Иргэдийн Төлөөлөгчдийн болон Нийтийн Хурлын ээлжит хуралдааныг улиралд нэг удаа хуралдуулдаг. Тайлант хугацаанд ИТХ-ыг 3 удаа, Нийтийн Хурлыг 1 удаа хуралдсан.

Үүнд:

№	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдсан огноо	Хурлаар	
		Хэлэлцсэн асуудал	Шийдвэрлэлт (тогтоолын дугаар)
1	2024.02.28	1. 2024 онд ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарьт нэмэлт өөрчлөлт оруулах тухай	01
2		2. Хог тээвэрлэх үнэ тогтоох тухай	02
3		3. Малын шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлах тухай	03
4		4. ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүйн дүрэм, дэд хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай	04
5		5. Сонгуулийн хэсэг байгуулах тухай	06
6	2024.04.25	6. Монгол улсын их хурлын сонгуулийн сурталчилгааны нэгдсэн болон зурагт самбарыг байрлуулах байршил тогтоох тухай	07
7		7. Сумын ИТХ-ын сонгуулийн тойрог байгуулж, тойрог ногдох мандатын тоо, дугаар, төвийг тогтоох тухай	08
8		8. Сонгуулийн хэсэг байгуулах тухай	09
9	2024.08.09	9. Сонгуулийн сурталчилгааны зурагт самбар болон ухуулах хуудсыг байрлуулах байршил тогтоох тухай	10

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1 Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Тус сумын ИТХ нь санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад санхүүгийн хууль тогтоомжийн хүрээнд УСНББОУС, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулж байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу эхний 3 дугаар улирлын байдлаар цахим системд нийт 135 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл зориулалтын дагуу зарцуулсан байдал

2.2.1 Батлагдсан төсөв:

2024 онд сумын ИТХ нь хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвийн дагуу орон нутгийн төсвөөс 121,050.8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 101,214.9 мянган төгрөгийг зарцуулж 19,835.9 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

2.2.2. 2024 оны үйл ажиллагааны батлагдсан төсөв, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулав:

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

Данс	Үзүүлэлт	2024 оны 3 улирал		Хэмнэлт /+/ Хэтрэлт /-/
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
	ХӨТӨЛБӨР 71702			
	АРГА ХЭМЖЭЭ 80101			
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	172,028.7	101,214.9	70,813.8
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	172,028.7	101,214.9	70,813.8
210	Бараа, үйлчилгээний зардал	172,028.7	101,214.9	70,813.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	127,040.6	74,377.4	52,663.2
210101	Үндсэн цалин	61,279.5	34,670.6	26,608.9
210102	Нэмэгдэл	46,494.7	29,698.4	16,796.3
210103	Унаа, болон бусад нөхөн олговор			-
210104	Урамшуулал	19,266.4	10,008.4	9,258.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,851.2	9,269.5	6,581.7
210201	Тэтгэврийн даатгал	10,851.8	6,313.5	4,538.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,257.1	743.0	514.1
210203	ҮОМШӨ ний даатгал	3,142.7	515.4	2,627.3
210204	Ажилгүйдлийн даатгал	599.6	356.0	243.6
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,341.5	(1,341.5)
2104	Хангамж, бараа материалын зардал	3,957.5	2,758.5	2,333.2
210401	Бичиг хэрэг	1,500.0	1,068.5	431.5
210402	Тээвэр (шатахуун)	2,000.0	1,500.0	500.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	457.5	190.0	267.5
2106	Эд хогшил худалдан авах	1,731.2	1,720.0	11.2
210602	Тавилга		1,720.0	
2107	Томилголт, зочны зардал	1,635.0	512.0	1,123.0
210702	Дотоод албан томилголт	1,635.0	512.0	1,123.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	-	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	-
210806	Мэдээллийн технологийн зардал			

2201	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000.0	1,590.0	8,410.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000.0	1,590.0	8,410.0
	АРГА ХЭМЖЭЭ 80215	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,731.2	1,716.8	14.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,731.2	1,716.8	14.4
210	Бараа, үйлчилгээний зардал	1,731.2	1,716.8	14.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,731.2	1,716.8	14.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,731.2	1,716.8	14.4
	ХӨТӨЛБӨР 71702	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80802	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,082.0	9,270.7	811.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	10,082.0	9,270.7	811.4
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,082.0	9,270.7	811.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,082.0	9,270.7	811.4
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	500.0	160.0	340.0
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	9,582.0	9,110.7	471.4
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	172,028.7	101,214.9	70,813.8

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:** 2024 оны эхний 3-р улирлын байдлаар цалингийн зардлаас үндсэн цалинд 46.6 хувийн, нэмэгдэл цалинд 39.9 хувийн, урамшуулалд 13.5 хувийн гүйцэтгэлтэй зарцуулсан байна.
- ЭМНДШ-ийн зардал:** 2024 оны төсөвт эрүүл мэндийн даатгалын дүнг төсөвлөж өгөөгүйгээс оны эхний 3 дугаар улирлын байдлаар 1,341.5 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн төлсөн байна.
- Хангамж бараа материалын зардал:** 2024 онд бараа материалын зардалд 3,957.5 мянган төгрөг батлагдаж эхний 3 дугаар улирлын байдлаар 2,758.5 мянган төгрөгийг зарцуулжээ. Бараа материал болон шатахууны зарцуулалтыг шаардах хуудас, маршрутыг үндэслэн зарлагдаж бүртгэсэн байна.
- Тавилга эд хогшил худалдан авах зардал:** 2024 онд 1,731.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний 3 дугаар улирлын байдлаар 1,720.0 мянган төгрөгийн зарцуулж тайлагнасан байна.
- Томилолтын зардал:** 2024 онд 1,635.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний 3 дугаар улирлын байдлаар 512.0 мянган төгрөгийн зарцуулж тайлагнасан байна.
- Бараа үйлчилгээний бусад зардал:** 2024 онд 10,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас эхний 3 дугаар улирлын байдлаар 1,590.0 мянган төгрөг зарцуулсан.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал:** 2024 онд 1,731.2 мянган төгрөг батлагдсанаас эхний 3 дугаар улирлын байдлаар 1,716.8 мянган төгрөгийг зарцуулсан баримттай байна.
- Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал:** 2024 онд сумдад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдад таван жил ажилласны мөнгөн урамшуулал олгох 9,582.0 мянган төгрөг батлагдсанаас 9,110.6 мянган төгрөгийг олгосон ба нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 500.0 мянган төгрөг батлагдсанаас 160.0 мянган төгрөгийг олгосон байна.

2.3. Санхүүгийн үйл ажиллагааны явц, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Үндсэн хөрөнгө: ИТХ нь 2024 оны эхэнд тоног төхөөрөмж 16,397.4 мянган төгрөг, тавилга эд хогшил 2,422.7 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд 4 камер 1,090.0 мянган төгрөгөөр, цагдаагийн торгуулийн төхөөрөмж 300.0 мянган төгрөгөөр, офиссийн ширээ, шүүгээ 1,720.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авч санхүүгийн бүртгэл тайланд тусгасан байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 5.4-т заасан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа"-тай тулган баталгаажуулахыг зөвлөв.

Бараа материал: 2024 онд 4,175.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч зарцуулсан нь баримтаар нотлогдож байна. 3-р улирлын байдлаар үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.

(мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хөдлөлийн утга	Орлого зарлагын гүйлгээний утга	Өмч хөрөнгө:	
			Үндсэн хөрөнгө	Бараа материал
1	Оны эхний үлдэгдэл		18,820.0	0.0
2	Төсвийн эх үүсвэрээр	худалдан авсан	3,110.0	4,175.3
3	Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс	шилжүүлэн авсан		
4	Бусад /дахин үнэлсэн/	шилжүүлэн авсан		
5	Бусад			
6	Орлогын дүн		3,110.0	4,175.3
7	Үйл ажиллагаанд зарцуулсан	анхан шатны баримт		4,175.3
8	Байгууллагуудад шилжүүлсэн	Шилжүүлсэн		
9	Акталж данснаас хассан	Тушаалаар		
10	Зарлагын гүйлгээний дүн		0.0	4,175.3
11	Оны эцсийн үлдэгдэл		21,930.0	0.0

2.4 Ажилтан албан хаагчдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал

2024 оны эхний хагас жилийн байдлаар сумын ИТХ-ын ажлын албаны цалинг 2 удаа шинэчлэн баталсан байна.

2024 онд сумын ИТХ-ын ажлын албанд ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэл хийсэн дүн шинжилгээ хийлээ:

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

№	Үзүүлэлт	ИТХ		БИНХ	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Үндсэн цалин	61,279.5	34,670.6		
2	Нэмэгдэл цалин	46,494.7	29,698.4		
3	Урамшуулал	12,066.4	2,824.4	7,200.0	7,184.0
4	Цалин хөлс нэмэгдэл дүн	119,840.6	67,193.4	7,200.0	7,184.0
5	Ажил олгогчоос төлөх НДШ	14,972.2	8,390.5	879.0	879.0
	Цалин хөлс НДШ-тэй холбоотой нийт зардлын дүн	134,812.8	75,583.9	8,079.0	8,063.0
	Орон тооны мэдээлэл	3	3	2	2

Сумын ИТХ нь 3, багийн иргэдийн нийтийн хурал 2, нийт 5 орон тоотойгоор үйл ажиллагааг явуулж цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 133,313.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 83,646.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгахад: ЭМД-ыг 2024 оны төсөвт суулгаж өгөөгүйгээс 1,341.5 мянган төгрөгийг зардал хооронд шилжүүлэн төлсөн байна.

2.5 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Тус сумын ИТХ нь 2024 онд төсвийн хөрөнгөөр 4 камер 1,090.0 мянган төгрөг, цагдаагийн торгуулийн төхөөрөмж 300.0 мянган төгрөг, офиссийн ширээ, шүүгээ 1,720.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авч санхүүгийн бүртгэл тайланд тусгасан байна.

2.6. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд хяналт тавих

Үндсэн хөрөнгө, бараа материалын худалдан авалт, анхан шатны баримтын иж бүрдлийг тулган шалгахад тайлант хугацаанд хийгдсэн худалдан авалт нь хууль, журмын дагуу бүртгэгдсэн байна.

2.7 Өмнөх шалгалтын талаар

Зөрчлийн шийдвэрлэлт	2024 оны 3 улирал				
	Үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	хувь
Төлбөрийн акт	1	1,577.8	1	1,577.8	100
Албан шаардлага	1	5,081.0	1	5,081.0	100
Нийт дүн	2	6,658.8	2	6,658.8	100

Төрийн аудитын байгууллагаас хийсэн хөндлөнгийн хяналт шалгалтаар 2023 онд ИТХ-ын дарга Ч.Гантөгсөд холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр 1,577.8 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй 5,081.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Гурав. Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ИТХ-ын 2024 оны эхний 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар журнал хөтлөлтөөр хангалттай сайн, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан зэрэг ололт бүхий нөхцөл байдал тогтоогдсон бол хууль тогтоомжийн хэрэгжилт, орлогын төлөвлөлттэй холбоотой дараах зөрчил, дутагдал илэрсэн. Үүнд:

Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудалтай холбоотой зөрчил дутагдал:

Илрүүлэлт 1. Малын тоо толгойн татварын орлогын төлөвлөгөөг төсөвлөхдөө өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслээгүй 37,999.0 мянган төгрөгөөр дутуу төсөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.", 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалтыг зөрчсөн байна, Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох: 5.2- "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт Малын тоо толгой татвар ногдуулахдаа ногдуулбал зохих малын тоо толгойн албан татварыг малын тоо толгойд үндэслэн бодитоор ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Ногдуулбал зохих газрын төлбөрийн албан татварыг бодитоор ногдуулаагүй 5,274.6 мянган төгрөгөөр дутуу ногдуулсан байна.

Энэ нь Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.Газрын төлбөрийг газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн тооцно." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт Сумын орлогод төвлөрөх газрын төлбөрийн татварыг ногдуулахдаа холбогдох байгууллагаас шаардлагатай тооцоо судалгааг гаргуулан бодитоор ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. ИТХ-ын даргын 2024 оны 01, 03, 05, 08, 10 дугаар захирамжаар 3,441.8 мянган төгрөгийг баталж ИТХ-ын ажлын албаны үйл ажиллагааны холбогдох зардлыг гаргасан байна.

Энэ нь Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх “Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хурлын нарийн бичгийн дарга тушаал гаргана.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хуулиар эрх олгосон захиргааны хэмж хэмжээний актын зүйл заалтыг үндэслэж тушаал гаргаж байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 4. Ашиглах боломжгүй болсон элэгдлээ бүрэн нөхсөн 512.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн судалгаа, тооцоог гарган сумын ИТХ-д актлах санал өгөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх “үнэн зөв байх”, 5.1.5 дах “хэмжигдэхүйц байх”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1 дэх “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт Цаашид үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглах боломжгүй, эдийн засгийн хувьд үр өгөөжгүй хөрөнгийн тооцоо судалгааг гарган актлуулах саналыг хүргүүлэх зөвлөмж өгөв.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

4.1 Дүгнэлт:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан удирдамжаар Хушаат сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтад хамрагдсан 2024 оны эхний 3 дугаар улирлын санхүү, төсөв, бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэйд тооцож, төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, сумын ИТХ-ын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааны горимыг баримталж ажилласан байна гэж дүгнэлээ.

4.2 Шийдвэрлэлт:

Хушаат сумын ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар нийт 47,228.2 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн хугацаатай 46,715.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 512.8 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав.Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж:

Шалгалтын явцад тус байгууллагын дарга, нягтлан бодогч, шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарал бүхий холбогдох албан хаагчтай уулзаж асуулга, тодруулга авч Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулсан болно.

Шалгалтаар илэрсэн зөрчилт үйлдлүүд нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл болох тул холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг ханган ажиллах шаардлагатай байгааг тус сумын ИТХ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, нягтлан бодогч, бусад холбогдох ажилтнуудад танилцуулж, зөвлөмж өгч шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг анхаарууллаа.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж 46,715.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн болно.

Шалгалтын тэмдэглэлд тусгагдсан үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллах, зөрчлийг арилгасан тухайгаа 2024 оны 12 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд албан бичгээр мэдэгдэхийг тус сумын ИТХ-ын ажлын албаны дарга, нягтлан бодогч нарт хариуцуулав.

БИЧСЭН:


САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАН ДОТООД АУДИТОР,
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГ



Ц.УРТНАСАН

ТАНИЛЦСАНЪ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ СУМЫН
ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА
НЯГТЛАН БОДОГЧ



Б.МӨНХЗУЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 120/32-03

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 15 дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны эхний 3 дугаар улирлын үйл ажиллагааны үр дүнд хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар Малын тоо толгойн татварын орлогын төлөвлөгөөг төсөвлөхдөө өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслээгүй 37,999.000 төгрөгөөр дутуу төсөвлөсөн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.", 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалтыг зөрчсөн байна, Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох 5.2- "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Малын тоо толгой татвар ногдуулахдаа өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн бодитоор ногдуулах.
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн

хяналт, дотоод аудитын албанд ирүүлэхийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Ж.Алтанцэцэг, нягтлан бодогч Б.Мөнхзул нарт даалгав.

3. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД
АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
Ц.УРТНАСАН



ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХУШААТ
СУМЫН ИТХ-Ы НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ж.АЛТАНЦЭЦЭГ
НЯГТЛАН БОДОГЧ Б.МӨНХЗУЛ





СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 121/32-03

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 15 дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны эхний 3 дугаар улирлын үйл ажиллагааны үр дүнд хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар Ногдуулбал зохих газрын төлбөрийн албан татварыг бодитоор ногдуулаагүй 5,274.600 төгрөгөөр дутуу ногдуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 "Газрын төлбөрийг газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн тооцно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сумын оргогод төвлөрөх газрын төлбөрийн татварыг ногдуулахдаа холбогдох байгууллагаас шаардлагатай тооцоо судалгааг гаргуулан бодитоор ногдуулах
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд ирүүлэхийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Ж.Алтанцэцэг, нягтлан бодогч Б.Мөнхзул нарт даалгав.

3. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
 АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД
 АУДИТОР САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
 ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
 Ц.УРТНАСАН



ЗӨВШӨӨРСӨН

СЭЛЭНГЭЭ	АЙМГИЙН	ХУШААТ
СУМЫН	ИТХ-НОНАРИЙР	БИЧГИЙН
ДАРГА		
НЯГТЛАН БОДОГЧ		ЖАВТАНЦЭЦЭГ
		Б.МӨНХЗУЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 11 сарын 10 өдөр

Дугаар 122/32-02

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын баталсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 15 дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны эхний 3 дугаар улирлын үйл ажиллагааны үр дүнд хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 01, 03, 05, 08, 10 дугаар захирамжаар нийт 3,441.830 төгрөгийг тус ажлын албаны үйл ажиллагааны холбогдох зардалд зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх "Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хурлын нарийн бичгийн дарга тушаал гаргана." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг авч хуулиар эрх олгосон захиргааны хэмж хэмжээний актын зүйл заалтыг үндэслэж тушаал гаргаж байх
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд ирүүлэхийг Иргэдийн төлөөлөгчдийн

хурлын нарийн бичгийн дарга Ж.Алтанцэцэг, нягтлан бодогч Б.Мөнхзул нарт даалгав.

3. Улсын байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16.2, Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.3-д зааснаар хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр төрөгнө.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД
АУДИТОР САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ
Ц.УРТНАСАН



ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭЭГЭР АЙМГИЙН ХУШААТ
СУМЫН ИТХ-Ы НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ж.АЛТАНЦЭЦЭГ
НЯГТЛАН БОДОГЧ Б.МӨНХЗУЛ

